

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ САЛБАР
ЗӨВЛӨЛ**

**5 дугаар хуралдаанаар хэлэлцсэн асуудлын тойм №5
2018.07.06**

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харъяа Буйр нуур-Мэнэнгийн талын, Галба-Өөш-Долоодын говийн, Орхон-Чулуут голын, Сэлэнгэ голын, Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны дарга (ахлах түшмэл ТЗ-8)-ын албан тушаалд сонгон шалгаруулалт явуулсан дүн, тухайн ажлын байрны албан тушаалд дүгнэлт гаргуулах, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Шүхэртийн Хангарьдыг Буйр нуур-Мэнэнгийн талын сав газрын захиргааны даргын албан тушаалын, Чанцалын Отгонбаатарыг Орхон-Чулуут голын сав газрын захиргааны даргын албан тушаалын, Махбалын Чулуунзагдыг Сэлэнгэ голын сав газрын захиргааны даргын албан тушаалын, Баатарын Ялалтбаярыг Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргааны даргын албан тушаалын, Батсүхийн Отгонсүрэнг Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны даргын албан тушаалын нөөцийн жагсаалтад бүртгэхээр болов.</p> <p>Сонгон шалгаруулалтаар 1 дүгээр байр эзэлсэн Шүхэртийн Хангарьдыг Буйр нуур-Мэнэнгийн талын сав газрын захиргааны даргын албан тушаалд, Чанцалын Отгонбаатарыг Орхон-Чулуут голын сав газрын захиргааны даргын албан тушаалд, Махбалын Чулуунзагдыг Сэлэнгэ голын сав газрын захиргааны даргын албан тушаалд, Баатарын Ялалтбаярыг Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргааны даргын албан тушаалд, Батсүхийн Отгонсүрэнг Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргааны даргын албан тушаалд тус тус нэр дэвшүүлж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбатад томилуулахаар санал болгов.</p>
2	<p>Цаг уур, орчны шинжилгээний газрын Хөвсгөл, Баянхонгор, Говь-Алтай аймаг дахь Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга нарын нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, дүгнэлт гаргаж өгөх тухай 2018-04-24-ний өдрийн 1/315 тоот албан бичгээр ирүүлсэн захиалгын талаар ТАЗ-өөс ирүүлсэн албан бичгийн тухай</p>	<p>1. Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшингээс 2018 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 1/452 тоот албан бичгээр ирүүлсэн Төрийн албаны зөвлөлийн 2018-05-30-ны өдрийн 575 дугаар албан бичигт дурдсан (Аймгийн ус цаг уур, орчны шинжилгээний газрын даргын томилгоотой холбоотой “Хариу ирүүлэхийг хүсэх тухай” 2018 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 1/151 тоот албан бичигтэй танилцлаа. Тоотод дурдсан хоёр аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний газрын даргын томилгоог Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийг баримтлан шийдвэрлэх боломжтой.) гэсэн нь тодорхой бус, мөн Хөвсгөл, Баянхонгор, Говь-Алтай аймаг дахь Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга нар нь Цаг уур орчны шинжилгээний газрын даргын 2016 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/92 дугаар тушаалаар аймаг хотын ус цаг уур орчны шинжилгээний албыг газар болгосон гэх үндэслэлээр албаны даргаас чөлөөлж газрын даргын түргэн орлон гүйцэтгэгчээр томилогдон ажиллаж байгаад чөлөөлөгдсөн нь шүүхийн шийдвэрээр үндэслэлгүй нь тогтоогдож албан тушаалууддаа эгүүлэн томилогдсон байсан тухай 2018 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 3 дугаар хуралдааны хоёрдугаарт хэлэлцэж нээлттэй сонгон шалгаруулалт дахин зарлах шаардлагагүй гэсэн шийдвэрийн төсөл хуралдаанд оруулж тэмдэглэсэн.</p>
3	<p>Тангараг өргүүлэх тухай</p>	<p>1.Төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 5, Цаг уур орчны шинжилгээний газраас 1, Сав газрын захиргааны 9 дарга, Туул голын сав газрын захиргааны 2 мэргэжилтэн нийт 17 иргэнийг Төрийн захиргааны албан хаагчийн тангараг</p>

		<p>өргүүлэхээр тогтов.</p> <p>2.Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын ажиллагааг 2018 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 12⁰⁰ цагаас ХААН танхимд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлигаар баталсан журмын дагуу зохион байгуулахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, холбогдох нэгжийн удирдлагууд, албан хаагчдад үүрэг болгов.</p>
4	<p>Бусад / өргөдөл-МТ.Лхагвадорж-М.Одхүү, ЦУОШГ-тай холбоотой асуудал АТГ, БХороо, шүүх, салбар зөвлөлийн тайлан мэдээ гаргах тухай/</p>	<p>1.Сонгон шалгаруулалтын комиссын 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн “Дүгнэлт”-ийг үндэслэн Мөнххайрханы байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны даргын албан тушаалд өрсөлдсөн Манжийн Одхүү, Тавьтайн Лхагвадорж нарын 2 иргэний оноог хавсралтаар баталж, Мөнххайрханы байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны даргын албан тушаалын нөөцийн жагсаалтад Манжийн Одхүү, Тавьтайн Лхагвадорж нарыг бүртгэж, Сонгон шалгаруулалтаар 1 дүгээр байр эзэлсэн Манжийн Одхүүг Мөнххайрханы байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны даргын албан тушаалд нэр дэвшүүлж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбатад томилуулахаар санал болгов.</p> <p>2.Байгаль орчин, аялал жуулчлалын яамны удирдлагуудад хандаж УИХ-ын Өргөдлийн байнгын хорооны 2018-06-11-ний өдрийн “Иргэний хүсэлт уламжлах тухай” 7/6862, Авлигатай тэмцэх газрын 2018-06-21-ний өдрийн “Иргэний гомдол, мэдээлэл шалгуулах тухай” 05/5336 тоот албан бичгээр ирүүлсэн Цаг уур орчны шинжилгээний газрын удирдлага зохион байгуулалт, төсөв, санхүү, хүний нөөцийн талаар гаргасан шийдвэрүүд болон тус газрын дарга С.Энхтүвшингийн талаарх гомдол, мэдээлэл шалгах ажлын хэсгийг байгуулахаар тогтов.</p>

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 5 дугаар хуралдаан 2018 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 9 цаг 30 минутаас 301 тоот өрөөнд болов.

Салбар зөвлөлийн хуралдаан №5 (2018.07.06)